

ОЛОН НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛ (ТЕЛЕВИЗ)-ЭЭР 2022 ОНЫ 2, 3 ДУГААР САРД ТҮГЭЭСЭН ЭМ, БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАР СУРТАЛЧИЛГААНД ТАНДАЛТ ҮНЭЛГЭЭ

ЭЭХХЗГ-Эмийн аюулгүй байдал, тандалт судалгааны газар

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ:

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 222 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар байгуулагдаж, эм зүйн салбарын нэгдсэн бодлого, төрийн үйлчилгээг нэг бүтцэд төлөвлөрүүлэн, хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн. Эмийн талаарх нотолгоонд суурилсан бодит мэдээллийг олон нийтэд түгээж зохистой хэрэглээг төлөвшүүлэх шаардлагатай байна.

Орчин үед эмийн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж, эмийн нэр төрөл олширч байгаа нь эмийг зөв сонгох, оновчтой хэрэглэхэд улам бүр төвөгтэй байдлыг бий болгож байгаа бөгөөд эмч, эм зүйч нар төдийгүй энгийн хэрэглэгчдэд ч үнэн зөв мэдээлэл чухал ач холбогдолтой болж байна.

Эмийн талаар төрөөс баримтлах бодлого, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Эрүүл мэндийн сайдын тушаал журмаар зохицуулагдаж байна.

2014 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Эмийн талаар төрөөс баримтлах бодлогод эмийн сурталчилгааг холбогдох хууль тогтоомж болон олон улсын хэмжээнд баримталдаг ёс зүйн хэм хэмжээний хүрээнд явуулах нөхцөл бүрдүүлнэ” гэж заасны дагуу эмийн зар сурталчилгааны зохицуулалт хийж эхэлсэн.

Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 17.1 “Эмийн тухай мэдээлэл нь үнэн зөв, бодитой бөгөөд үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгчээс хараат бус байна”, 17.2 “Эмийн тухай бодит мэдээллээр эрүүл мэндийн байгууллага, мал эмнэлэг, хүн амыг хангах ажлыг төрийн захиргааны холбогдох төв байгууллагын зөвшөөрснөөр мэргэжлийн байгууллага зохион байгуулж хэрэгжүүлнэ” гэж заасан, “Жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг мэргэжлийн болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно.” 27.2-т Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хянана.” гэж тус тус заасан байна.

Мөн зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1. “Олон нийтийн мэдээлэх хэрэглэсээр зөвхөн жоргүй олгох эмийн тухай болон эмийг зохистой хэрэглэхтэй холбогдсон сурталчилгаа явуулж болно” гэж заасан байдаг.

Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг сурталчилах зөвшөөрлийг зөвхөн улсын бүртгэлд бүртгэгдсэн бүтээгдэхүүнд Эм судлалын салбар зөвлөлийн шийдвэрийн дагуу агуулгыг нь баталгаажуулан олгож байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/295 дугаар тушаалын “Эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг бүртгэх журам” -ын 1.13. БИБ гэдэгт хүний бие махбодын хэвийн үйл ажиллагааг дэмжих, шаардлагатай шимт бодис, илчлэгийг нөхөх үйлчлэл бүхий бүтээгдэхүүн хамаарах бөгөөд БИБ-нийг хүний **өвчнийг эмчлэх, оношлох зорилгоор** хэрэглэхгүй. мөн 1.16. БИБ-ний бүртгэлд “Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль”-ийн 22.7-д зааснаас гадна үйлдвэрлэгч улсдаа хүнсний ангилалд орсон бүтээгдэхүүнд хамаарахгүй.

ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Манай хүн амын дунд эмийн зохистой хэрэглээний талаар мэдлэггүй атлаа эмийг дур мэдэн хэрэглэснээр эмийн гаж нөлөө илрэх, эмэнд дасах, хордох тохиолдол элбэгшиж, эрүүл мэнд амь насаараа хохирох, эмчилгээний үр нөлөө буурах, эмийн харшил, нянгийн халдвар хүнд явцтай болох зэрэг үзэгдэл ихсэж байгаа нь эмч мэргэжилтнүүдийн сэтгэлийг зүй ёсоор түгшээж байна.

Эмийг зохисгүй хэрэглэснээр эмнээс улбаатай эрүүл мэндийн эрсдлээс өөрийгөө хамгаалах, эмийг зөв ухаалгаар хэрэглэх аргыг иргэдэд зааж сургах явдал тулгамдсан асуудлын нэг болсон.

ДЭМБ-аас “Олон нийтийг хамарсан эмийн зохистой хэрэглээний сургалт” нь ялангуяа хөгжиж буй орнуудад тулгарч буй шийдвэрлэвэл зохих асуудлын нэг мөн гэж үзэж Зүүн өмнөд азийн хэд хэдэн оронд болон манай улсын 2,3 шатлалын эмнэлгүүдэд эмийн зохиостой хэрэглээг Эмнэлэгт яаж төлөвшүүлэх, иргэдэд эмийг зөв хэрэглэх дадал заншилд сургах аргын талаар сургалт сурталчилгааны ажлыг эхлүүлсэн нь амжилттай хэрэгжиж байна.

Эмийн зохистой хэрэглээг алдагдуулж буй олон шалтгааны нэг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарим эмийг хэт шүтэх байдлаар илэрч болох гаж нөлөөг орхигдуулж өрөөсгөл сурталчилдаг.

1.1. Зорилго

Хүн амд эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн, үнэн бодит биш мэдээллээр хангахаас сэргийлэх зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж байгаа эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаанд үнэлгээ хийх

1.2. Зорилт

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээн хүн амд хүрч буй эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг үнэлэхдээ Монгол Улсын эм,

биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэл, хэрэглэх заавар, Эм судлалын салбар зөвлөлийн хурлын шийдвэрээр зөвшөөрөл авсан эсэх, хуулийн заалт зөрчсөн эсэхийг хянаж Microsoft Office Excel программыг ашиглан боловсруулалт хийнэ.

1.3. Үнэлгээний арга зүй

- Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа зөвшөөрөл авсан эсэх
- Монгол улсын эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлд бүртгэлтэй эсэх
- Тухайн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны агуулгын хүрээнд мэдээллийг түгээж байгаа эсэх

1.4. Үнэлгээний хамрах хүрээ:


- Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)
- Эм ханган нийлүүлэх байгууллага
- Дотоодын эмийн үйлдвэрлэгч
- Гадаад, дотоодын эм үйлдвэрлэгчийн төлөөлөгчийн газар

ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

ЭМ БИОЛОГИЙН ИДЭВХТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАР СУРТАЛЧИЛГАА

2021 онд зар сурталчилгааны зөвшөөрлийг 78 нэрийн эм, 15 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүнд олгосон байна.

Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнд олгосон зар сурталчилгааны тоо 2016-2021



Дүрслэл.1

2.2 Мэдээлэл цуглуулалт

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээж байгаа жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны хяналт мэдээллийг “Максима медиа” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу авсан.

2022 оны 02 дугаар сарын 1-нээс 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний мэдээлэл, ЭССЗ-ийн 2021, 2022 оны

хурлын шийдвэрээр зөвшөөрөл олгогдсон эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны мэдээлэл, Монгол Улсын эмийн бүртгэлийн цахим веб-д сууриалсан цахим системийн www.licemed.gov.mn мэдээллийн баазыг ашиглан хяналт хийж дүн шинжилгээ хийсэн.

2021 онд нийт 93 эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл олгогдсон байна.


Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа олгогдсон нийт тоо



2017 болон 2020 онд 59 буюу хамгийн бага зар сурталчилгааны зөвшөөрөл олгогдсон байна. 2019 онд нийтдээ 136 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зөвшөөрөл олгогдсон байна. (Дүрслэл.2)

Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг 29 өргөн нэвтрүүлэгийн болон арилжааны телевизүүдээр түгээсэн байна.

Эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны эзлэх хувь




Дүрслэл.3

ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэж зөвшөөрөл авч түгээсэн 23 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн 37.0%, 39 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн буюу 62.9% нь Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцэж зөвшөөрөл аваагүй. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн байна.


Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа



■ Зөвшөөрөл аваагүй ■ Зөвшөөрөл авсан


Дүрслэл.4

2022 оны 2,3 дугаар сард Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны тоо



■ эм ■ биологийн идэвхт бүтээгдэхүүн ■ хүнс

ЭССЗ-ийн хурлын шийдвэрээр жоргүй олгох эмийн зар сурталчилгааны зөвшөөрөл авсан эсэх



■ зөвшөөрөл аваагүй ■ зөвшөөрөл авсан

Дүрслэл.6


2022 оны 02 дугаар сарын 1-нээс 03 дугаар сарын 31-ний хүртэлх хугацаанд 29 өргөн нэвтрүүлэгийн болон арилжааны телевизүүдээр 29 эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэх байгууллагын 62 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн байна. Үүнээс эмийн зар сурталчилгаа 32, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа 30 түгээсэн байна. 2 нэрийн хүнсний ангилалаар хилээр орж ирдэг бүтээгдэхүүн байна.

Жоргүй олгох эмийн зар сурталчилгаа 32 нэрийн түгээснээс 13 нэрийн буюу 40.6% нь ЭССЗ-ийн хурлын зөвшөөрөл авч олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн. 19 нэрийн буюу 59.3% нь эмийн зар сурталчилгаа ЭССЗ-ийн хурлын зөвшөөрөлгүй олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн байна.

Дүрслэл.5

Биологийн идэвхт бүтээгдэхүүний 30 зар сурталчилгаа түгээснээс 6 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүн 20% нь ЭССЗ-ийн хурлын зөвшөөрөл авч олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн. 24 нэрийн биологийн идэвхт бүтээгдэхүүн буюу 80% нь Монгол улсад бүртгэлтэй биологийн идэвхт бүтээгдэхүүн байгаа бөгөөд, ЭССЗ-ийн хурлын зөвшөөрөлгүй олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн байна.

Эм Судлалын Салбар Зөвлөлийн хурлын шийдвэрээр биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны зөвшөөрөл авсан эсэх




■ зөвшөөрөл аваагүй ■ зөвшөөрөл авсан

Дүрслэл.7

Хуулийн заалт зөрчсөн (хүүхдэд хандсан эмийн сурталчилгаа явуулах;) 12 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн байгаагаас ЭССЗ-ийн хурлын шийдвэрээр зөвшөөрөл аваагүй түгээсэн байна.

Хуулийн заалт зөрчсөн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа



■ хүүхдэд хандсан ■ онцгой эрхтэй ■ чанартай, №1

Хуулийн заалт зөрчсөн (эмийг ховор, чухал, цорын ганц, маш өндөр идэвхтэй, үр дүн нь бусад эмээс илүү, аюулгүй, гаж нөлөөгүй, шинэ эм, патентлагдсан гэж хэрэглэгчийг төөрөгдүүлэх;) 4 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний 1 нь ЭССЗ-ийн хурлын шийдвэрээр зөвшөөрөл авсан ба 3 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн ЭССЗ-ийн хурлын шийдвэрээр зөвшөөрөл аваагүй түгээсэн байна.

Дүрслэл.8

ДҮГНЭЛТ:

2022 оны 02 дугаар сарын 1-нээс 03 дугаар сарын 31-ний хүртэлх хугацаанд 29 өргөн нэвтрүүлэгийн болон арилжааны телевизүүдээр 29 эм, биологийн идэвхт бүтээгдэхүүн ханган нийлүүлэх байгууллагын 62 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааг Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн байна. Үүнээс эмийн зар сурталчилгаа 32, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа 30 түгээсэн байна. 2 нэрийн хүнсний ангилалаар хилээр орж ирдэг бүтээгдэхүүн байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээсэн 62 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгааны 19 нэрийн эм, биологийн

идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа 30.6% нь зөвшөөрөл авсан байна. 43 нэрийн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний 69.3% зөвшөөрөл аваагүй түгээсэн байна.

Хүнсний бүтээгдэхүүний ангилалаар Монгол улсын хилээр орж ирдэг Алтан Тоонот ХХК-ний Пептид, Global trend Mongolia-ийн Нано бальзам бүтээгдэхүүнийн нь эмчилгээний үйлдэл үзүүлнэ гэж ард иргэдийг төөрөгдүүлсэн зар сурталчилгаа явуулж байна. Иймд эдгээр бүтээгдэхүүнийг хуулийн дагуу хянаж шалгах шаардлагатай.

Нэвтрүүлэгийн ерөнхий ивээн тэтгэгчээр хамтран ажилласан байгууллагуудын нэрийг дурдаж байна. Үүнд: Dr. Baatar, МЭИК, Эрүүл мэндийн карт, Doppel herz, Natures Plus, Цахиур төмөр ХХК, Vitos цэнэг, Fohow MNU03 төлөөлөгчийн газар, Natures Plus, Lenus-med эдгээр байгууллагууд байна.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (телевиз)-ээр түгээж байгаа эм, биологийн идэвхт бүтээгдэхүүний зар сурталчилгаа нь Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, ард иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөхөд чиглэгдсэн байх бөгөөд тухайн эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг хэт дөвийлгөх, хэрэглэгчийг төөрөгдүүлэх, тухайн эмийн гаж үйлчлэлийг нуун далдлах зорилготой байж болохгүй.